



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/26/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	15-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-19
4. Аудитын тайлан	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	22-23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24-25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
ЗҮҮНХАРАА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Ц.ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/26-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь бидний тогтоосон 20,246.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон 3 багшийн ажилласан хоногийг зөрүүтэй

тооцож 1,088.1 мянган төгрөгийн цалин илүү тооцсон, 20 багшид зэргийн нэмэгдэл 1,469.1 мянган төгрөгийг давхардуулан олгосон,

- Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч Р.Н.Үүрцайх, Б.Энхцэцэг, нярав Ж.Бямбасүрэн нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 2,379.0 мянган төгрөг олгосон.
- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ыг илүү шилжүүлэн 28,103.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Дезерет ОУБ-с 25,864.7 мянган төгрөгийн ор, угаалгын машин үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 4 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	269,741,730.00	351,939,791.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	27,741,342.61
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	27,741,342.61
31210	Төгрөг	0.00	27,741,342.61
31211	Төрийн сангийн харилцах	0.00	27,741,342.61
33	АВЛАГА	545,853.00	29,623,041.49
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	545,853.00	28,103,041.49
335	Бусад авлага	0.00	1,520,000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	1,520,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	269,195,877.00	294,575,407.00
351	Түүхий эд материал	1,209,900.00	1,329,900.00
3513	Эм боох материал	1,209,900.00	1,329,900.00
35400	Хангамжийн материал	252,057,227.00	277,166,757.00
3542	Аж ахуйн материал	37,870,249.00	41,961,349.00
3543	Сэлбэг хэрэгсэл	108,571,164.00	110,251,164.00
3545	Барилгын засварын материал	32,820,600.00	37,157,400.00
3546	Хүнсний материал	5,614,444.00	6,946,774.00
3547	Бусад хангамжийн материал	67,180,770.00	80,850,070.00
356	Мал амьтад	15,928,750.00	16,078,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,622,115,424.36	2,567,558,806.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,622,115,424.36	2,567,558,806.29
39200	Биет хөрөнгө	1,936,834,840.81	1,884,696,806.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,640,455,655.43	1,640,455,655.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(260,724,900.27)	(312,523,883.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	438,785,363.00	438,785,363.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(351,588,851.48)	(352,388,851.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	794,937,511.40	820,177,211.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(446,049,654.20)	(483,579,165.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,219,911.00	165,469,911.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(119,011,279.17)	(122,079,120.75)
39209	Зам, гүүрийн байгууламж	93,233,800.00	93,233,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(71,050,621.73)	(77,074,271.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	134,913,778.52	135,843,778.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	(74,558,586.69)	(87,071,885.37)
39217	Ном	18,272,715.00	25,448,265.00
39300	Биет бус хөрөнгө	685,280,583.55	682,862,000.14
39301	Програм хангамж	20,848,000.00	20,848,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,749,416.45)	(20,167,999.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	682,182,000.00	682,182,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,891,857,154.36	2,919,498,597.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,872,327.67	0.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,872,327.67	0.00
413	Өглөг	6,872,327.67	0.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,872,327.67	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,884,984,826.69	2,919,498,597.39
51	Засгийн газрын хувь оролцоо	2,884,984,826.69	2,919,498,597.39
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,505,912,180.56	1,505,912,180.56
51200	Хуримтлагдсан үр дүн	229,733,622.03	264,247,392.73
51210	Өмнөх үеийн үр дүн	229,733,622.03	229,733,622.03
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	34,513,770.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,149,339,024.10	1,149,339,024.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,891,857,154.36	2,919,498,597.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,059,837,309.60	2,777,580,064.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,535,000.00	38,894,997.00
120	Нийтлэг татварын бус орлого	75,535,000.00	38,894,997.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,935,000.00	6,600,297.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,600,297.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	74,935,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	25,864,700.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	600,000.00	6,430,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,984,302,309.60	2,738,685,067.75
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,779,264,200.00	2,520,665,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,779,264,200.00	2,520,665,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,371,109.60	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,371,109.60	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	202,667,000.00	218,019,567.75
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	202,667,000.00	218,019,567.75
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,022,525,618.51	2,742,466,294.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,022,525,618.51	2,742,466,294.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,929,977,297.97	2,631,090,206.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,197,322,196.57	1,756,306,854.45
210101	Үндсэн цалин	714,933,105.71	969,309,127.18
210102	Нэмэгдэл	295,383,492.81	637,978,498.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,616,196.62	42,477,910.00
210104	Урамшуулал	147,389,401.43	106,541,319.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,578,000.00	223,853,600.00

210201	Тэтгэврийн даатгал	102,107,611.67	152,220,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,188,736.56	17,908,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,968,014.35	8,954,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,326,830.25	8,954,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,986,807.17	35,816,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,910,437.27	191,574,640.08
210301	Гэрэл, цахилгаан	34,051,905.25	31,665,827.92
210302	Түлш, халаалт	146,144,861.02	143,083,399.20
210303	Цэвэр, бохир ус	9,713,671.00	16,825,412.96
2104	Хангамж, бараа материалын зардал	43,596,500.89	2,773,600.00
210401	Бичиг хэрэг	5,002,200.00	1,829,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,223,880.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,009,310.89	0.00
210404	Ном, хэвлэл	324,160.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,640,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,396,950.00	944,200.00
2105	Нормативт зардал	61,966,350.00	79,842,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,156,950.00	0.00
210502	Хоол, хүнс	56,034,300.00	79,842,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,775,100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,958,475.00	31,318,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,571,225.00	16,357,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,170,900.00	0.00
210604	Урсгал засвар	35,216,350.00	14,961,400.00
2107	Томилолт, зочны зардал	7,551,600.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,551,600.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,315,593.00	31,680,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,450,000.00	31,680,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,200.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	529,950.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	137,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,666,000.00	0.00
210807	Газрын төлбөр	48,443.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,778,145.24	313,740,711.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,789,416.00	85,180,727.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	71,230,380.00	114,408,115.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,758,349.24	114,151,868.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,548,320.54	111,376,088.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,924,014.00	111,376,088.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	41,827,200.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	56,044,014.00	66,058,888.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	880,000.00	3,490,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,624,306.54	0.00 1324100015 9055436
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,624,306.54	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,311,691.09	35,113,770.70
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,168,750.00	600,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	35,142,941.09	34,513,770.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,984,302,309.60	2,745,831,217.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	7,146,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	7,146,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,146,150.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,146,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,984,302,309.60	2,738,685,067.75
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,779,264,200.00	2,520,665,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,779,264,200.00	2,520,665,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,371,109.60	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,371,109.60	0.00
1330	Төсвийн захирагчаас	202,667,000.00	218,019,567.75
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	202,667,000.00	218,019,567.75
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,935,847,709.60	2,718,089,875.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,935,847,709.60	2,718,089,875.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,843,299,389.06	2,606,713,787.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,193,468,049.57	1,784,409,895.94
210101	Үндсэн цалин	711,078,958.71	997,412,168.67
210102	Нэмэгдэл	295,383,492.81	637,978,498.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,616,196.62	42,477,910.00
210104	Урамшуулал	147,389,401.43	106,541,319.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,578,000.00	223,853,600.00
210201	Тэтгэврийн даатгал	102,107,611.67	152,220,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,188,736.56	17,908,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,968,014.35	8,954,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,326,830.25	8,954,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,986,807.17	35,816,600.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,038,109.60	198,446,967.75
210301	Гэрэл, цахилгаан	32,154,621.32	33,563,111.85
210302	Түлш, халаалт	141,169,817.28	148,058,442.94
210303	Цэвэр, бохир ус	9,713,671.00	16,825,412.96
2104	Хангамж, бараа материалын зардал	36,549,550.89	0.00
210401	Бичиг хэрэг	5,002,200.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	7,223,880.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,009,310.89	0.00
210404	Ном, хэвлэл	324,160.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,640,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,350,000.00	0.00
2105	Нормативт зардал	68,771,700.00	81,174,730.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,156,950.00	0.00
210502	Хоол, хүнс	53,509,750.00	81,174,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,105,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,312,350.00	24,046,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,159,400.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,065,900.00	16,570,000.00
210604	Урсгал засвар	45,087,050.00	7,476,400.00
2107	Томилолт, зочны зардал	7,551,600.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,551,600.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,194,093.00	31,680,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,328,500.00	31,680,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,200.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	529,950.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	137,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,666,000.00	0.00
210807	Газрын төлбөр	48,443.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,835,936.00	263,102,193.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,789,416.00	120,058,277.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	87,046,520.00	143,043,915.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,924,014.00	111,376,088.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,924,014.00	111,376,088.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	41,827,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	56,044,014.00	66,058,888.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	880,000.00	3,490,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,624,306.54	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,624,306.54	0.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	48,454,600.00	27,741,342.61
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,454,600.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,454,600.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,454,600.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	45,354,600.00	0.00
223001	Бусад хөрөнгө	3,100,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(48,454,600.00)	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	27,741,342.61
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,741,342.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	229,733,622.03	2,884,984,826.69
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	34,513,770.70	34,513,770.70
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	229,733,622.03	2,884,984,826.69
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	34,513,770.70	34,513,770.70
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	264,247,392.73	2,919,498,597.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,747,186,600.00	2,718,089,875.14	29,096,724.86	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,747,186,600.00	2,718,089,875.14	29,096,724.86	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,630,022,300.00	2,606,713,787.14	23,308,512.86	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,790,829,300.00	1,784,409,895.94	6,419,404.06	99.6
210101	Үндсэн цалин	1,054,032,300.00	997,412,168.67	56,620,131.33	94.6
210102	Нэмэгдэл	657,939,200.00	637,978,498.25	19,960,701.75	97.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,857,800.00	42,477,910.00	36,379,890.00	53.9
210104	Урамшуулал	0.00	106,541,319.02	(106,541,319.02)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,853,600.00	223,853,600.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	152,220,500.00	152,220,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,908,300.00	17,908,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,954,100.00	8,954,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,954,100.00	8,954,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	35,816,600.00	35,816,600.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,796,600.00	198,446,967.75	6,349,632.25	96.9
210301	Гэрэл, цахилгаан	40,829,800.00	33,563,111.85	7,266,688.15	82.2
210302	Түлш, халаалт	144,271,900.00	148,058,442.94	(3,786,542.94)	102.6
210303	Цэвэр, бохир ус	19,694,900.00	16,825,412.96	2,869,487.04	85.4
2105	Нормативт зардал	81,210,000.00	81,174,730.00	35,270.00	100.0
210502	Хоол, хүнс	81,210,000.00	81,174,730.00	35,270.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,133,700.00	24,046,400.00	87,300.00	99.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,633,700.00	16,570,000.00	63,700.00	99.6
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,476,400.00	23,600.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,624,500.00	31,680,000.00	8,944,500.00	78.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,624,500.00	31,680,000.00	8,944,500.00	78.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264,574,600.00	263,102,193.45	1,472,406.55	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,525,100.00	120,058,277.95	1,466,822.05	98.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	143,049,500.00	143,043,915.50	5,584.50	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,164,300.00	111,376,088.00	5,788,212.00	95.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,164,300.00	111,376,088.00	5,788,212.00	95.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,827,200.00	41,827,200.00	0.00	100.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	71,837,100.00	66,058,888.00	5,778,212.00	92.0

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,490,000.00	10,000.00	99.7
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,745,831,217.75	2,745,831,217.75	0.00	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,520,665,500.00	2,520,665,500.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,520,665,500.00	2,520,665,500.00	0.00	100.0
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС	218,019,567.75	218,019,567.75	0.00	100.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчдаас олгосон санхүүжилт	218,019,567.75	218,019,567.75	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,146,150.00	7,146,150.00	0.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,146,150.00	7,146,150.00	0.00	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,741,342.61		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын Зүүнхараа Политехник коллеж нь 2024 онд “Чанартай сургалт- Чадамжтай төгсөгч” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Дотооддоо хөндлөнгийн үнэлгээг суралцагчийн мэдлэг, ур чадвар, чадамжийн түвшинг бодитой үнэлдэг болох,
- Багшийг шинээр болон давтан бэлтгэх агуулга арга хэлбэрийг тодорхойлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах,
- Суралцагчид дараагийн түвшний сургалтын байгууллагад дэвших, үе тэнгийн бусад суралцагчидтай ижил хөтөлбөрөөр суралцаж мэдлэг, ур чадвар эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх,
- Бүс нутгийн онцлог, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн элсэлтийг зохион байгуулж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;

- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Зүүнхараа Политехник коллеж нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мандал сумын Зүүнхараа Политехник коллеж нь Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр

дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,641.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		27,741.3	27,741.30
Авлага	545.9	29,623.00	29,077.10
Бараа материал	269,195.90	294,575.40	25,379.50
Үндсэн хөрөнгө	2,622,115.40	2,567,558.80	(54,556.60)
Нийт хөрөнгө	2,891,857.20	2,919,498.50	27,641.30
Өр төлбөр	6,872.30		(6,872.30)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,884,984.80	2,919,498.50	34,513.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,891,857.20	2,919,498.50	27,641.30

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 27,741.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны үлдэгдэл 29,623.0 мянган төгрөг болж 29,077.1 мянган төгрөгөөр өссөн нь 28,103.0 мянган төгрөгийн ХХОАТ илүү шилжүүлсэн, 1,520.0 мянган төгрөгийн багажны урьдчилгаа төлбөр шилжүүлснээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 294,575.4 мянган төгрөг болж 25,379.5 мянган төгрөгөөр өссөн нь 750.0 мянган төгрөгийн 2 тугал орлого авсан, Дезерет ОУБ-с 5,680.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн болон төсвийн хөрөнгөөр 297,136.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 278,187.0 мянган төгрөгийн бараа материалы зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,022,444.0 мянган төгрөг болж 59,595.3 мянган төгрөгөөр өссөн нь Дезерет ОУБ-с 25,864.7 мянган төгрөгийн ор, угаалгын машин үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 33,730.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авсан болон 114,151.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь өмнөх оны гэрэл цахилгаан, тулш халаалтын 6,872.30 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,249,023.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 214,425.1 мянган төгрөг зэрэг нийт 1,463,448.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 159,372.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт төсвийг 1,622,821.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур 4 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 1,089,497.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,771.9 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 18,000.0 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 12,096.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 1,124,365.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс 2,520,665.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 226,521.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар нийт төсвийг **2,747,186.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улс, орон нутгийн төсвөөс нийт 2,747,186.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,718,089.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,718,089.9 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлыг 29,096.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71804 Мэргэжлийн боловсрол	1	80219- Харуул хамгаалалтын зардал	38,496.0	31,679.8	6,816.2	82.3
		2	81806- Дотуур байрны үйлчилгээ	81,210.0	81,174.7	35.3	100.0
		3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	117,164.3	111,376.1	5,788.2	95.1
		4	81834- Боловсролын стандарт сургалт	2,194,299.0	2,192,024.7	2,274.2	99.9
		5	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	96,574.6	95,911.0	663.6	99.3
		6	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	212,296.6	205,923.6	6,373.0	97.0
		7	83602-ЗД нөөц хөрөнгөөс хуваарилсан	7,146.2		7,146.2	0.0
	Нийт			2,747,186.6	2,718,089.9	29,096.7	98.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулаагүй, үнийн харьцуулалт хийлгүйгээр мах, махан бүтээгдэхүүнийг “Шүүтийн өвөр” ХХК, хичээлийн практикийн материал, хүнс, бичиг хэрэг, цэвэрлэгээний материалыг “Томон” ХХК, Дэлгэрэх гялбаа ХХК, “Ноцох дөл” ХХК, “Шинэ шүүдэр” ХХК-иудтай гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,024,694.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 20,246.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын Зүүнхараа Политехник коллеж нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 157 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг мэдээлэн, тухай бүр мэдээлэх 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт – 6 удаа,
- Санхүүгийн тайлан-1 удаа,
- Батлагдсан төсөв – 1 удаа,

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Н.Үүрцайхад **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Шүүтийн өвөр” ХХК, Томон ХХК, Ноцох дөл ХХК-тай шууд гэрээ байгуулж, хоол, хүнсний худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын

1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүйгээс 6,872.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл хоцроосон зөрчилд албан шаардлага, хөрөнгийн ангилал, бүртгэлийг холбогдох стандарт, журмын дагуу үнэн зөв бүртгэх нэг зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	6,872.3	1	6,872.3	50.0
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	3	6,872.3	2	6,872.3	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.Өмнөх оны ажлыг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 50.0 хүртэл хувиар тооцож, үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал БШУЯ-ны 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар албан бичгээр 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогч Н.Үүрцайх, Б.Энхцэцэг, нярав Ж.Бямбасүрэн нарт 2 сарын үндсэн

цалинтай тэнцэх буюу нийт **7,930.0** мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **67,698.3** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Худалдан авсан 6,606.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг шууд зардалд бүртгэж, тайлагнасан.
2. ХХОАТ-ын илүү шилжүүлсэн 28,103.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, гэрэл цахилгааны өр төлбөрийг 1,897.3 мянган төгрөгөөр илүү тусгасан,
3. Үр дүнгийн тайланд 545.8 мянган төгрөгийн урьд оны авлагыг орлогоор тусгасан, цалингийн зардлыг 28,648.9 мянган төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой зардлыг 1,897.3 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан гэх мэт.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” , 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **33,039.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **4,936.2** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28,103.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Акт тогтоох:

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалж 20 багшид зэргийн нэмэгдэл 1,469.1 мянган төгрөгийг давхардуулан илүү тооцож, олгосон байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон 3 багшийн ажилласан хоногийг зөрүүтэй тооцож, 1,088.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаарын сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч Н.Үүрцайх, Б.Энхцэцэг, нярав Ж.Бямбасүрэн нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 2,379.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3: “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ыг илүү шилжүүлэн 28,103.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлага тусгаагүй	1	28,103.0	1	28,103.0			1	28,103.0				
Өглөг илүү тусгасан	1	1,897.3	1	1,897.3			1	1,897.3				
Аж ахуйн	1	6,606.0			1	6,606.0	1	6,606.0				

материалыг шууд зардалд бүртгэсэн													
Зардал зөрүүтэй илэрхийлсэн	1	30,546.2			1	30,546.2	1	30,546.2					
Үр дүнгийн тайланд урьд оны авлагыг орлогоор тусгасан	1	545.8			1	545.8	1	545.8					
Дүн	5	67,698.3	2	30,000.3	3	37,698.0	5	67,698.3					



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Цалин илүү олгосон	3	4,936.2	3	4,936.2									
Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын авлага үүсгэсэн	1	28,103.0			1	28,103.0							
Дүн	4	33,039.2	3	4,936.2	1	28,103.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Нийт дүн	1				1			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1				1			
Дүн	1				1			
Нийт дүн	2				2			-